



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/81

Чингис хот

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг бусдад
шилжүүлэх тухай

Монгол улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн өргөдөл гаргасан Б.Гантөгс, Б.Ган-Очир нарт холбогдох бичиг баримтыг үндэслэн газар эзэмших эрхийн гэрчилгээг хавсралтад дурдсанаар 2 иргэний 2 нэгж талбарыг шилжүүлсүгэй.


2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэдэд газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, гэрээ байгуулан биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг газрын мэргэжилтэн (Ж.Эрхэмбаяр)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор сумын Засаг даргын 2012 оны 90 тоот захирамжийн дээрх иргэдэд холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР



Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны
07 дугаар сарын 01-ны өдрийн /2025.07.01/ тоот
захирамжийн хавсралт

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх нэрсийн жагсаалт

д/д	Шилжүүлсэн хүний эцэг/эх/-ийн нэр, нэр	Газрын зориулалт	Газрын хэмжээ	Эзэмшил газрын байршил	Шилжүүлэн авсан иргэн ААНБ-ын нэр	Хугацаа	Шилжүүлэх үндэслэл
1	Бэгзсүрэн Гантөгс /ЦГ65062201/	Гэр, орон сууцны хашааны газар	700 м2	Хэнтий, Хэрлэн 1-р баг, Нисэх 11-02	Батбаяр Шинэбилэг /ЕЭ76052960/	47	Эрх шилжүүлэх гэрээ
	Батболд Ган-Очир /БЮ86071538/	Гэр, орон сууцны хашааны газар	700 м2	Хэнтий, Хэрлэн 1-р баг, Нисэх 11-01	Батбаяр Шинэбилэг /ЕЭ76052960/	47	Эрх шилжүүлэх гэрээ